

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал...	7
2.9 Аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаархи тайлбар, тодруулга	8
2.11 Шилэн дансны мэдээлэл	8
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаархи тайлбар, тодруулга.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ
ИНСТИТУТИЙН ЗАХИРАЛ
М.АЛТАНСҮХ ТАНАА

2019.02.25 № 06/233
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус институтын захирал М.Алтансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаархи тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаархи тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Төгс нягт гурав аудит" ХХК-ий захирал Д.Цэнд хянан удирдаж, чанарын хяналтын менежер З.Тунгалаг, аудитор Д.Эрдэнэтуяа, аудиторын туслах С.Баярсайхан нар хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 тоот албан бичгээр хуулийн хугацаанд тус компанид ирүүлсэн

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаархи бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрхи стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрхи бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн талаархи ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Тус байгууллага нь 2016 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үндсэн зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ, хэтийн болон ойрын тооцоолол хийж, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага юм.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг томоохон бодлогын баримт бичигт холбогдох хууль журам, тэдгээр журмыг шинэчлэхэд шаардлагатай суурь тоон мэдээлэл, зөвлөмжөөр хангах зорилтын хүрээнд “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”, “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Малчдын аж байдал, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал” зэрэг судалгааг хийж үр дүнг тайлагнасан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны инстиутийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрхи бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “AXPLORER 3.16” програм хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзсэнтэй холбоотой юм.

2018 оны санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 2018 онд 779,323.3 мянган төгрөг байгаа бөгөөд түүний 1 хувь болох 7,793.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Дүн	1	0.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулав.

2.9 Аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын дансанд бүртгэлтэй байсан 3.653.226.758 төгрөгийн /элэгдэлтэй дүнгээр/ оффисийн барилгыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ий өдрийн 31 тоот тогтоолоор ХХҮЕГ-ын дансанд балансаас балансанд шилжүүлсэн болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаархи тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд 541,140.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 524,758.9 мянган төгрөг буюу батлагдсан төсвийн 97 хувийг зарцуулж үлдэгдэл 16,381.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар байгууллагын rilsp.gov.mn вэбсайт хуудсанд хугацаанд нь оруулж хяналт тавьж ажилласан байна. 2018 оны 11 дүгээр сард Үндэсний аудитын газраас шилэн дансны хэрэгжилтийн талаар аудит хийсэн, аудитаар зөрчил илрээгүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаархи тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаархи мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж

1.1 Илрүүлэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны Санхүүгийн тайлангийн аудитын явцад тус байгууллагын ашиглаж байгаа санхүүгийн Explorer 3.16 программ ерөнхий журнал, зардлын тооцооллыг удаа дараалан буруу татсан, мөн орлогын журналын тооцоололгүй байв.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тооцооллыг буруу илэрхийлэх;

1.3 Зөвлөмж:

Санхүүгийн програмыг сайжруулах, зөв болгох;

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээрх зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, асуудлын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулсан. Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхээр тогтов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,564,375.00	31,343,401.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	257,850.00
33402	Татвар, НДШ – ийн авлага		257,850.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,564,375.00	31,085,551.00
354	Хангамжийн материал	32,564,375.00	31,085,551.00
35410	Бичиг хэргийн материал	6,095,192.00	8,326,477.00
35420	Аж ахуйн материал	128,000.00	108,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	660,000.00	1,248,945.00
35440	Түлш, шатах тослох материал	3,002,000.00	2,175,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,679,183.00	19,227,129.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,442,451,869.07	189,011,177.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,442,451,869.07	189,011,177.42
392	Биет хөрөнгө	3,441,226,896.85	122,493,887.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,653,226,758.50	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	(388,155,343.09)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	163,377,700.00	163,377,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(130,976,784.82)	(153,212,234.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	237,878,479.27	237,878,479.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(187,421,789.35)	(203,626,314.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161,646,189.89	161,646,189.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,899,313.55)	(89,120,932.35)
39217	Ном	5,551,000.00	5,551,000.00
393	Биет бус хөрөнгө	1,224,972.22	66,517,289.48
39301	Програм хангамж	1,331,000.00	84,882,930.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(106,027.78)	(18,365,640.52)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,475,016,244.07	220,354,578.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,475,016,244.07	218,354,578.42
51	Засгийн газрын хувь оролцоо	3,475,016,244.07	218,354,578.42
512	Хуримтлагдсан үр дүн	3,475,016,244.07	218,354,578.42
51210	Өмнөх үеийн үр дүн	3,475,016,244.07	3,475,016,244.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,256,661,665.65)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,475,016,244.07	220,354,578.42

4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан
/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,897,483,965.84	726,845,930.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,648,597,865.84	99,205,930.00
1200	Өмчийн орлого	3,648,597,865.84	99,205,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,648,597,865.84	99,205,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,648,597,865.84	99,205,930.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,886,100.00	627,640,000.00
1310	Улсын төсвөөс	243,886,100.00	541,140,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	243,886,100.00	541,140,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	86,499,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	86,499,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	215,627,879.18	779,323,292.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,627,879.18	779,323,292.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,281,563.86	762,942,038.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,221,215.00	463,441,698.00
210101	Үндсэн цалин	125,221,215.00	351,012,698.00
210102	Нэмэгдэл	-	40,307,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,027,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	45,095,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,999,704.91	55,452,250.25
210201	Тэтгэврийн даатгал	9,007,404.26	39,478,291.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,029,418.88	3,837,609.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,252,212.16	3,144,099.95
210204	Ажилгүйдлийн даатгал	246,424.50	860,999.46
210205	Эрүүл мэндийн даатгал	2,464,245.11	8,131,250.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,258,861.00	-
210301	Гэрэл, цахилгаан	17,473,387.00	-
210302	Түлш, халаалт	7,873,894.00	-
210303	Цэвэр, бохир ус	911,580.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	17,655,485.00	91,223,586.19
210401	Бичиг хэрэг	4,198,745.00	13,236,915.00
210402	Тээвэр, шатахуун	2,352,000.00	35,301,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,777,240.00	21,977,667.19
210404	Ном, хэвлэл	-	17,582,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,500.00	-

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,995,000.00	3,125,204.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,733,600.00	3,624,605.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,624,605.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,000.00	-
210604	Урсгал засвар	3,703,600.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,623,421.00	7,818,500.00
210702	Дотоод албан томилолт	4,623,421.00	7,818,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,620.00	7,583,080.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,120.00	739,710.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	322,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,500.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	455,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	172,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,030,656.95	133,798,318.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,510,000.00	640,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,520,656.95	132,808,318.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,346,315.32	16,381,254.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,381,254.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,381,254.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,711,029.32	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,711,029.32	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,635,286.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,635,286.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,204,184,302.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,681,856,086.66	(52,477,362.88)
145/4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН(V)	-	3,204,184,302.77
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		3,204,184,302.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,204,184,302.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,681,856,086.66	(3,256,661,665.65)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	248,886,100.00	627,640,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,886,100.00	627,640,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	243,886,100.00	541,140,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	243,886,100.00	541,140,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	86,499,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	86,499,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	248,886,100.00	627,255,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,886,100.00	627,255,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,539,784.68	610,873,745.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,699,493.91	463,441,698.00
210101	Үндсэн цалин	143,699,493.91	326,820,639.00
210102	Нэмэгдэл	-	55,490,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	36,036,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	45,095,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,863,000.00	55,710,100.25
210201	Тэтгэврийн даатгал	10,114,450.61	39,736,141.01
210202	Тэтгэмжийн даатгал	1,180,668.64	3,837,609.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,274.33	3,144,099.96
210204	Ажилгүйдлийн даатгал	284,236.95	860,999.46
210205	Эрүүл мэндийн даатгал	2,842,369.47	8,131,250.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,879,782.00	-
210301	Гэрэл, цахилгаан	20,770,013.00	-
210302	Түлш, халаалт	7,873,894.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,235,875.00	-
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	24,035,167.77	74,343,567.19
210401	Бичиг хэрэг	7,064,510.00	13,959,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,919,000.00	34,919,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,192,557.77	21,977,667.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	547,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,311,600.00	3,487,000.00
2105	Нормативт зардал	828,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	828,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,342,300.00	2,274,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,520,800.00	2,274,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,702,000.00	-
210604	Урсгал засвар	4,119,500.00	-

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	4,623,421.00	7,818,500.00
210702	Дотоод албан томилолт	4,623,421.00	7,818,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,620.00	5,583,080.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,120.00	739,710.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	322,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,500.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	455,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	172,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,510,000.00	1,702,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,510,000.00	1,352,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,346,315.32	16,381,254.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,381,254.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,381,254.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,635,286.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,635,286.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,711,029.32	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,711,029.32	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	385,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	385,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	385,000.00
2200	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	385,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	385,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛА-ГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛА-ГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,657,393,273.89	-	3,657,393,273.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(72,994,832.68)	-	(72,994,832.68)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,584,398,441.21	-	3,584,398,441.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(109,382,197.14)	-	(109,382,197.14)
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,475,016,244.07	-	3,475,016,244.07
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,475,016,244.07	-	3,475,016,244.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,475,016,244.07	-	3,475,016,244.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(3,256,661,665.65)	-	(3,256,661,665.65)
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	218,354,578.42	-	218,354,578.42

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл				
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,519,700.00	418,346,698.00	12,173,002.00	97
210101	Үндсэн цалин	333,196,600.00	326,820,639.00	6,375,961.00	98
210102	Нэмэгдэл	61,287,100.00	55,490,059.00	5,797,041.00	91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,036,000.00	36,036,000.00	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,662,200.00	50,298,700.25	1,363,499.75	97
210201	Тэтгэврийн даатгал	34,441,500.00	34,324,741.01	116,758.99	100
210202	Тэтгэмжийн даатгал	4,305,200.00	3,837,609.32	467,590.68	89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,444,100.00	3,144,099.96	300,000.04	91
210204	Ажилгүйдлийн даатгал	861,000.00	860,999.46	0.54	100
210205	Эрүүл мэндийн даатгал	8,610,400.00	8,131,250.50	479,149.50	94
2104	Хангамж, бараа материалын зардал	40,331,300.00	38,987,167.19	1,344,132.81	97
210401	Бичиг хэрэг	12,640,500.00	12,640,000.00	500.00	100
210402	Тээвэр, шатахуун	6,768,600.00	6,768,500.00	100.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,701,200.00	16,357,667.19	1,343,532.81	92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,221,000.00	3,221,000.00	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,274,600.00	2,274,600.00	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,274,600.00	2,274,600.00	-	100
2107	Томилолт, зочны зардал	8,581,100.00	7,531,500.00	1,049,600.00	88
210702	Дотоод албан томилолт	8,581,100.00	7,531,500.00	1,049,600.00	88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,419,100.00	5,968,080.00	451,020.00	93
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	742,500.00	739,710.00	2,790.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552,700.00	322,370.00	230,330.00	58
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,057,900.00	840,000.00	217,900.00	79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,200.00	1,352,200.00	-	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,200.00	1,352,200.00	-	100

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	*ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
31	Улсын төсвөөс санхүүжих	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
122001	Улсын төсвөөс санхүүжих	541,140,200.00	524,758,945.44	16,381,254.56	97
122002	Үндсэн үйл ажиллагааны зардал		(16,381,254.56)	16,381,254.56	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	40.00	6.00	34.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
610001	Төсвийн байгууллага	-	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	6.00	34.00	
620001	Удирдах ажилтан	7.00	-	7.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	6.00	15.00	
620003	Үйлчлэх ажилтан	12.00	-	12.00	
620004	Гэрээт ажилтан	-	-	-	

4.6 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тохируулга	Цэвэр
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	0.00		0.00
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
1	НИЙТОРЛОГО	541,140,201.00	16,381,254.56	524,758,946.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,140,202.00	16,381,254.56	524,758,947.44
1310	Улсын төсвөөс	541,140,203.00	16,381,254.56	524,758,948.44
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	541,140,204.00	16,381,254.56	524,758,949.44
2	НИЙТ ЗАРДАЛ	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,519,700.00	12,173,002.00	418,346,698.00
210101	Үндсэн цалин	333,196,600.00	6,375,961.00	326,820,639.00
210102	Нэмэгдэл	61,287,100.00	5,797,041.00	55,490,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,036,000.00	-	36,036,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,662,200.00	1,363,499.75	50,298,700.25
210201	Тэтгэврийн даатгал	34,441,500.00	116,758.99	34,324,741.01
210202	Тэтгэмжийн даатгал	4,305,200.00	467,590.68	3,837,609.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,444,100.00	300,000.04	3,144,099.96
210204	Ажилгүйдлийн даатгал	861,000.00	0.54	860,999.46
210205	Эрүүл мэндийн даатгал	8,610,400.00	479,149.50	8,131,250.50
2104	Хангамж, бараа материалын зардал	40,331,300.00	1,344,132.81	38,987,167.19
210401	Бичиг хэрэг	12,640,500.00	500.00	12,640,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,768,600.00	100.00	6,768,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,701,200.00	1,343,532.81	16,357,667.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,221,000.00	-	3,221,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,274,600.00	-	2,274,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,274,600.00	-	2,274,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,581,100.00	1,049,600.00	7,531,500.00
210702	Дотоод албан томилолт	8,581,100.00	1,049,600.00	7,531,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,419,100.00	451,020.00	5,968,080.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	-	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	742,500.00	2,790.00	739,710.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552,700.00	230,330.00	322,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,057,900.00	217,900.00	840,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,200.00	-	1,352,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,200.00	-	1,352,200.00
3	*ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ҮҮСВЭР			
31	Улсын төсвөөс санхүүжих	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
122001	Улсын төсвөөс санхүүжих	541,140,200.00	16,381,254.56	524,758,945.44
122002	Үндсэн үйл ажиллагааны зардал		16,381,254.56	(16,381,254.56)
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр, нийгмийн хмагааллын судалгааны институтийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код
2019.02.18			ҮАГ/САГ-2019/81/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	Мянган төгрөгөөр

№	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
1	Санхүүгийн тайлангийн программ нь ерөнхий журналыг алдаатай татдаг, орлогын журналын тооцоололгүй	0.00	Зөвлөмж	2019.02.18		Захирал	М.Алтансүх

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

[illegible]